

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Хоршоо хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар батлуулан зээл олгон ажиллалаа.

Е- Mongolia: Цахим системээс Иргэний үнэмлэхийн лавлагаа – 2, авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа - 1, жолооны үнэмлэхийн лавлагаа-2, нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт – 15, иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа – 4, НАХЯ-ны хилийн ба дотоодын цэрэгт цэргийн алба хаасан тухай архивын лавлагаа - 2 , нийт - 26 лавлагаа олголоо.

Эх үрсийн баярын үйл ажиллагааг нэгдсэн хөтөлбөрөөр зохион байгуулж алдарт эхийн 2 дугаар зэргийн одонг 4 эхчүүдэд гардуулж, хүүхдүүдийн дунд бөх, гүйлт, дугуйн уралдааныг зохион байгуулж ажилласан.

Сүхбаатар аймгийн сурын холбооноос тэргүүн, гоц харваач ирж Үндэсний сурын спортыг сонирхогчдод сургалт зохион байгуулан ажилласан.

СҮХБААТАР ӨНГӨ сонинд 7 хоног бүрийн 4 дэх өдөр болгон сонинд хэвлэгдэх мэдээллээ явуулан ажиллаж байна.

Хагас жилийн мал тооллогыг сумын ЗД-ын 2023.05.26 өдрийн А/66 тоот захирамжийн дагуу зохион байгууллаа. Мал тооллогын түүвэрт 4 багийн 90 өрх сонгогдож тооллогыг 2023.05.31-06.04 хооронд хийж, дүн мэдээг нэгтгэн илтгэх хуудас, тайлбар тодруулга, төл хорогдлын мэдээний хамт 2023.06.15 өдөр аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлээ.

Пэйж хуудсанд энэ сар нийт 16 пост(мэдээ мэдээлэл) оруулсан. Халзан сумын албан ёсны вэб сайт болох Khalzan.su.gov.mn хандах эрхийг олж авч веб сайтны хөгжүүлэлт болон нэмэх зүйл дээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ХНУМС-д төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон цалингийн өөрчлөлт, төрийн захиргааны албан хаагчийн ангилал зэрэглэлийг шинэчлэн орууллаа.

6-р дүгээр сард нийт ирсэн бичиг 15, хариутай -6, үүнээс хугацаанд нь илгээсэн - 5, хугацаа болоогүй -1, явсан бичиг -10 байна.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД:

6 дугаар сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 59.2 сая төгрөг авч орон нутгийн төсвийн байгууллагуудад 73.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Худалдан авах ажиллагааны tender.gov.mn сайтад зарласан Хог зөөврийн автомашиныг 64.5 сая төгрөгөөр, Ариутгалын дук машиныг 82.8 сая төгрөгөөр “Оточ оргил ХХК” нийлүүлэхээр шалгарсан байна.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн пүрэв гаригт цахимаар зохион байгуулагддаг сургалтад нийт 17 албан хаагчдыг хамруулж ажиллалаа.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2023 оны 06 сарын 05-ны өдөр тус суманд ажиллаж дараах чиглэлээр сургалт зохион байгуулав.

1. “Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Хүний эрхэд суурилсан хандлага” - Хүний эрхийн Үндэсний Комиссын Сүхбаатар аймаг дахь ажилтан, референт Х.Наранцэцэг.

2. “Гэмт хэргийн хохирогч, холбогдогч болохоос урьдчилан сэргийлэх” - Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгчийн туслах Б.Цолмон

3. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг” - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын орлогч дарга ахмад М.Батмөнх.

4. Аймгийн ИТХ-ын хууль эрх зүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Сэргэлэнбаяр нар сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай танилцах, шалган зааварчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүд болон байгууллагын дарга удирлагууд, төрийн алба хаагч нарт сургалт, мэдээлэл өгч ажиллалаа.

Засгийн газрын гишүүн Сангийн дэд сайд С. Мөнгөнчимэгийн 6 сарын 13 ны өдөр иргэд хөдөлмөртэй уулзалт хийж, Шинэ сэргэлтийн бодлого үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх танилцуулга хийж ажиллав.

Эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалтад 2 албан хаагч сууж гэрчилгээ гардан авлаа.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Ерөнхий боловсролын сургууль: 5-р сарын 27ны өдрөөс 6-р сарын 8-ны өдрийг хүртэл анги дэвших болон улсын шалгалтын хичээлийг амжилттай зохион байгуулсан.

6-р сарын 2нд бага ангийн багш нар “Аймгийн бага ангийн багш нарын зөвлөгөөнд хамрагдсан.

Эрэгтэй эмэгтэй технологийн хичээлийн тайлант өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр сурагчдын хийсэн бүтээлийн үзэсгэлэнг гаргаж эцэг эх, ард иргэд, асран хамгаалагч нарт танилцууллаа.

6-р сарын 12-13 ны өдрүүдэд Баруун-урт хотноо сургуулийн захирал С.Эрдэнэтуяа 2022-2023 оны хичээлийн жилийн тайланг тавьж, удирдах ажилтны сургалт семинарт хамрагдлаа.

6-р сарын 15-ны өдөр 9-р анги төгсөж байгаа нийт 18 сурагчдад “Суурь боловсрол”-ын гэрчилгээг гардууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн төв нь 06 сард Улаанбурхан улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтанд 10 сартайгаас 8 нас хүртэлхи 204 хүүхдийг вакцинд бүрэн хамруулсан.

2023 оны 06 сард Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал Үйлчүүлэгчийг танин тодруулах, Амилуулах тусламж үйлчилгээний сургалтанд эмч мэргэжилтэнгүүд ЭМГ-т сургалтанд хамрагдсан .

Мал эмнэлэгийн чиглэлээр: Сүхбаатар аймгийн засаг даргын 2023 оны 05 сарын 22 ны өдрийн 03 дугаар албан далгаварын хүрээнд сумын засаг даргын 2023 оны 05 сарын 25 ны өдрийн А/ тоот “Сэг зэм устгах ажлын хэсгийн хэсэг” захирамжийн дагуу байгалийн гамшигт үзэгдлийн улмаас хорогдсон малыг сумын 4 багийн 4 байрлалд ЗДТГ, ОНӨҮГ-ийн ажилчид Мал эмнэлгийн тасаг, МЭҮН-ийн малын эмч нар, 4 багийн засаг дарга нартай хамтран булж устгах ажлыг зохион байгуулсан.

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 01 албан даалгаврын хүрээнд сумын төвийн орчны цэвэрлэгээ , малын хүүр сэг зэм цуглуулах ажлын хүрээнд төсөвт байгууллагын 20 албан хаагчид сумын ойролцоох хувиарт 1-2 км газарт цэвэрлэгээ хийлээ.Мөн үнсний голыг цэгцлэх, зүй бусаар хорогдсон малыг хогийн цэгт замбараагүй хаясаны улмаас зүй бусын хорогдлоор хорогдсон малыг хаях газаргүй болсон учир Үнсний голыг цэгцлэх ажлыг эхлүүлсэн. Цориулалтын цэгт төвлөрүүлэх ажлын эхэлж, сумын зарын грүүпээр мэдээлэлийг тавьж ажилсан.Сумын хэмжээнд 8704 мянган толгой малаас 750 ыг зориулалтын бэлдсэн цооногт булж устгаж ариутгал халдваргүйтгэлийг хийсэн.

Сүхбаатар аймгийн засаг даргын 2023 оны 05 сарын 22 ны өдрийн 03 дугаар албан далгаварын хүрээнд сумын засаг даргын 2023 оны 05 сарын 25 ны өдрийн А/ тоот “Сэг зэм устгах ажлын хэсгийн хэсэг” захирамжийн дагуу байгалийн гамшигт үзэгдлийн улмаас хорогдсон малыг сумын 4 багийн 4 байрлалд ЗДТГ, ОНӨҮГ-ийн ажилчид Мал эмнэлгийн тасаг, МЭҮН-ийн малын эмч нар, 4 багийн засаг дарга нартай хамтран зохион байгуулж гамшигийн үед хорогдсон малын судалгааг багийн дарга нараас авч ажилсан. Сумын хэмжээнд 21931 мянган толгой мал хорогдсоноос адуу 547, үхэр 737, хонь 11017 ямаа 9630 хорогдоод байна. 4 байршилд 3-р баг хужиртай, 4-р баг үнсний гол, 1-р баг овооны энгэрт 4 байршилд адуу 467, үхэр 720, хонь 6929, ямаа 5962 нийт 14100 мянган толгой малыг устгаад байна. 64.3 %-ийн гүйцэтгэлтэй байна.

Байгаль орчны чиглэлээр: Төвлөрсөн хогийн цэгийг цэгцлэх, үхсэн малын сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулж төвлөрсөн хогийн цэгт 6 нүх ухаж үхсэн малын сэг зэмийг булшлан ариутгал халдваргүйжилтийн ажлыг хийж хогийн цэгт 4 га газрын хогийг цэвэрлэн ил талбай гаргав. Түлш шатахууны зардалд 5 сая 400 мянган төгрөгийн зардал гаргав.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 02 тоот албан даалгаварын биелэлтийг гаргаж аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлэв

Байгаль хамгаалах зардлаас 64.5 сая төгрөгөөр хог зөөврийн өөрөө буулгагч КАМА маркийн авто машиныг худалдан авлаа.

Байгалийн нөөц ашигласаны тухай хуулийн хэрэгжилт түүнийг захиран зарцуулах тухай зөвлөгөөн Баруун-Урт суманд болж үүнд сумын ИТХ-ын дарга Ө. Золжаргал, Санхүү төрийн сангийн мэргэжилтэн Д. Гэрэлцэцэг нарын хамт оролцлоо

Халзан овооны зүүн урд талд нийтийн бие засах газрыг Халзан дулаан ОНӨААТҮГ-аар хийж гүйцэтгүүлээ.

Сумын төвийн айл өрхүүдийн хашааны элсийг зөөж цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэлээ

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:
М.ХУЯГ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Д.ДАЙРИЙМАА